

“ЧИНГИСИЙН ОНГОН ХААНА БАЙНА ВЭ?” ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

Д.ЗОРИГТ*

“Өвөр монголын өдрийн сонин”-ы 2000 оны гуравдугаар сарын 1-ний дугаарт Бээжин дэх Төвийн үндэстний их сургуулийн профессор Чэнь Сыжуны бичсэн “Чингис хааны онгон шарил хаана байна вэ?” гэсэн гарчигтай өгүүллийг тус сургуулийн багш Сэцэнгийн орчуулгаар нийтэлснийг товчлон сийрүүлэв.

... Чингис хаан 1227 онд баруун зүг дайлаад буцаж ирснийхээ дараа нас нөгчөөд эдүгээ 722 жил болж байна. Түүнийг насан өөд болсны дараа үр хойчис нь түүний гэрээсийг дагаж, нууцаар оршуулсан бөгөөд шарил онгоныг нь ил тавилгүй далдалсан билээ.

Чингис хааны онгон ба Юань улсын олон үеийн хаадын онгон эртний монгол хаант улсын нийслэл Хар хорумын бууриас хойш гучин газрын үзүүр дэх эртний Сэлэнгэ мөрний эх үүсвэрт байх юм. Дэлхийн бөмбөрцгийн зүүн уртрагийн 104 градусаас баруун тийш, умард өргөрөгийн 48 градусаас өмнүүр одоогийн Орхон голын хоёр эргээр бий гэжээ.

Арвангуравдугаар зууны Персийн алдарт түүхч Рашидын дэлхий дахинаа алдаршсан том бүтээл болох “Судрын чуулган”-ы монголын баяд аймгийн тухай танилцуулсан хэсэгт Чингис хааны онгоныг “Сэлэнгэ мөрний дээд урсгалын хоёр эх үүсвэр, тухайлбал Бор өндөр, Гурван хийд хэмээх хоёр газарт бий” хэмээн өгүүлжээ. Энэ газар бол их цээр хоригтой газар бөгөөд түүнийг мянган ойрад сахиж байсан гэнэ. Энэхүү Сэлэнгэ мөрөн бол эдүгээгийн Сэлэнгэ мөрөн биш, харин Хар хорумын хажууд байсан эртний нэгэн мөрөн юм. Тухайлбал Мөнх хааны үеийн Персийн өөр нэгэн их түүхч Жувейнийн бичсэн алдарт бүтээл “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” хэмээх номонд тодорхой

өгүүлсэн Хар хорумын хажуу дахь Сэлэнгэ мөрөн мөн. Юань улсын үеийн хятадын их эрдэмтэн Юй Жи “Бумбын хүрээлэн дор эртний судар бичгийг сурсан тэмдэглэл”-дээ “Хар хорум хэмээгч уулнаа Сэлэнгэ хэмээх нэгэн мөрөн буй. Энэ мөрөн нь Хар хорумын хажууд баймой” гэжээ. Юань улсын дунд ба сүүлийн үеийн Оу Янсюань хэмээгч хятадын их түүхч “Гуй жай-өргөөний уянгын түүвэр”-тээ “Хар хорум хэмээх газар болбоос эдүгээгийн Хорум болой. Тэнд гурван гол буй. Хотын өмнөх уулнаа нийлээд зүүн хойш урсахуйг нь Орхон гол, хотын баруун талаар өнгөрч, хойш урсахуйг нь Хорум гол, хотын баруун хойноос эх авч, зүүн тийш урсахуйг нь Гурван тамир гол хэмээнэ. Энэ гурван гол нь Хар хорум хотоос хойш гучин газрын үзүүрт урсгал нийлж, үүнийг нь Сэлэнгэ мөрөн хэмээмүй” гэж тэмдэглэжээ. Гэхдээ урсгал нийлсний дараа үүссэн Сэлэнгэ мөрөн бол даруй Рашид, Жувейни, Юй Жи нарын номондоо өгүүлсэн Хар хорумын хажуу дахь Сэлэнгэ мөрөн болно. Мөн “Юань улсын судар”-ын “Чингис хааны цадиг”-т өгүүлсэн Чингисийн шарилыг оршуулсан Сэлэнгэ мөрөн мөн. Чингис хааны онгон энэ голын ойролцоо буюу эхэнд байх нь лавтай.

“Юань улсын судар”-ын ёслол хөгжмийн тэмдэглэлд сонгон оруулсан өвөг дээдсээ тахиx тахилгын дууны үг Чингис хааны онгон Хар хорумын хажууд байгаа гэдгийг дахин гэрчилж байна.

“Юань улсын судар”-ын “Тайзун хааны хоёрдугаар өрөө”-ний дууны үгэнд “Хар хорум хэмээх гайхамшигт сайхан нутаг болбоос тэнгэрийн тагт, газрын оршил мөн буюу” гэж тэмдэглэжээ. Газрын оршил гэдэг бол хааны онгоныг зааж байна. Үүнийг орчлон ертөнцийн хүмүүс бүр ухах бөлгөө. Энэ үгийн санаа нь монгол хаант төрийн нийслэл Хар

*Д.Зоригт.ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан.

хорум бол маш чухал дархан газар бөгөөд Юань улсын тайзун Өгөөдэй хааны онгон шарил байгаа газар мөн гэжээ. Үүнээс үзвэл энэхүү бадаг дууны үгийн түүхэн материалд Юань улсын эзэн хааны газрын оршил байгаа нутгийг зааж өгүүлэх үүднээс Чингис хааны онгон оршил бол Хар хорумын хажууд байгааг дагм байдлаар тодорхойлсон учир болно. Юань улсын өвгөдийн сүмийн дуу хөгжмийн үг бол Чингис хааны үр ач болох хаад ноёдоос дээдсийнхээ нөгчсөн сүнсийг гашуудан тахих үед дуулж байсан дуу мөн бөгөөд түүний агуулгыг Чингис хааны онгон байгаа газрыг лавтай сайн мэддэг эрх мэдэгч эзэн хаад хянасны дараа сая дуулдаг аж. Иймээс энэ дуунд заасан Чингис хааны онгон оршлын газар орон бол нэн үнэмшилтэй юм.

Чингис хааны омбол Юань улсын тулгар төрийг үндэслэсэн Хубилай хааны ач чэнзун хаан Төмөрийн хэлсэн “Чингис хааны онгон оршил болбоос Хар хорум хэмээх эртний бууриас хойш гучин газрын үзүүрт байгаа Сэлэнгэ мөрний эх үүсвэрт буй” гэх сургаал үг үүнийг гэрчилж байна.

Өмнөх магадлалыг үндэслээд “Чингис хааны онгон байгаа газар бол дэлхийн бөмбөрцгийн зүүн уртрагийн 104 градусаас баруун тийш, умард өргөрөгийн 48 градусаас өмнүүр, Сэлэнгэ мөрний эх үүсвэрт буй” хэмээн эртний хүмүүсийн хэлснийг бид мэдлээ.

Рашид Чингис хааны онгон Хар хорумын хажуу дахь Сэлэнгэ мөрний эх үүсвэрт буй хэмээсэн. Юань улсын чэнзун хаан Төмөр Хар хорумын ойролцоо бий гэж хэлсэн. Рашид өөрийн тэмдэглэлээ Чингис хааны онгон хөвгүүн болох Ил хаант улсын Хасан хааны гүн ордон дахь Алтан дэвтрээс авсан юм. Юань улсын чэнзун хаан ба Хасан хаан хоёр бол Чингис хааны гэр бүлээс гаралтай хаад болно. Тэд анх 13 дугаар зуунд Чингис хааны онгоны жинхэнэ байгаа газрыг нийтэлсэн байна. Тэдний олгож өгсөн энэ хоёр түүхэн материалын үндэс баримт нь тун их үнэ цэнтэй болой. Учир нь Чингис хааны онгон хаана байгаа тухай гаднын хүмүүсийн хэлсэн үгийг итгэж болохгүй. Харин түүний гэр бүлийн хойч үеийн хаадын хэлсэн үг хамгийн үнэмшилтэй юм.

Дээрхи гурван зүйлийн үндэс баримтыг гол болгон Чингис хааны онгон байгаа

газрын тухай шинэ үзэл бодлыг дурдахад эрт эдүгээ дотоод гадаадад яригдсан хуучин үзэл сургаалын талаар бас зөвлөн ярилцах нь зүйтэй юм.

Зөвлөн ярилцваас зохих эхний зүйл гэвэл Чингис хааны шарилыг эзэн хороонд оршуулсан гэж үздэг явдал юм. Энэ нь үнэмших өчүүхэн ч үндэслэлгүй зүйл мөн. Энэ газар бол өмнүүрээ монголын хаант төртэй үеийн үедээ өшөө хорсолтой Алтан улстай ойр зэргэлдээ бөгөөд мөхөөд удаагүй байсан тангудын хуучин нутаг болно. Тийм болохоор Чингис хааны үр хүүхдүүд эцгийнхээ шарилыг яасан ч өстөн дайсны хил хязгаар дотор буюу эсвэл саяхан мөхсөн улсын хуучин нутагт үл тавих ажгуу.

Няцааваас зохих хоёрдахь зүйл гэвэл Чингис хааны шарилыг Бурхан халдунд оршуулсан гэх үзэл бодол юм. Энэ бол “Монголын нууц товчоо”-ноос эш авсан үзэл юм. Харь улсын хайн шинжих чин зоригтнууд энэ газарт үлэмж олон өрөмдөж нүхэлсэн боловч үр дүн гаргаж чадаагүй билээ.

Няцаавал зохих гуравдахь зүйл нь Юань улсын үе дэх Италийн Марко Поло хэмээгч хүний өгүүлсэн “Чингис хааны шарилыг Алтайн уулнаа оршуулав” гэсэн үзэл юм. Алтайн уул нь уудам цэлгэр, үзүүр хязгааргүй үргэлжилсэн тоо томшгүй олон уул хайрхануудаас бүрддэг. Тэрбээр аль уул хайрхан, ямар гуу жалганд оршуулсныг тодорхой заасангүй тул энэхүү үг нь туйлын бүдэг балархай болжээ.

Зөвлөн ярилцваас зохих дөрөв дэх зүйл гэвэл “Умар зүгт дайлсан тэмдэглэл”-д “Хэрлэн голын зүүн хойд зүгт нэгэн өндөр уул баймой. Юань улсын олон хаадыг энэ уулын хажууд оршуулжээ” гэсэн буй. Энэ нь Чингис хааны онгоныг түүний дотор тавив гэсэн санаа буюу. Үүнд үнэмшилтэй зүйл огтхон ч алга. Учир нь “Юань улсын судар”, “Судрын чуулган” зэрэг номонд Чингис хааны онгоныг уул товцог, гол мөрний эх үүсвэрт байна” гэжээ. Тэгвэл энэ хоёр ном бол “Умар зүгт дайлсан тэмдэглэл”-ээс аль эрт зохиогдсон бөгөөд нэн үнэмшилтэй юм.

Тав дахь зүйл гэвэл Юй Минжи хэмээгч хүний “умард Юань улсын эзэн хаанаас Чингис хааны онгоныг Ордост шилжүүлэн аваачив” гэсэн яриа бөгөөд энэ нь тун ч дэмий балай санаа юм. Умард Юань улс Мин

улстай эрх тэгш болохоор тэмцэлдэж, хоёр талын цэрэг бат чанга бэхлэлт хийсэн нөхцөлд Ордос хоёр талын цэргийн тулалдааны талбар болж байсан болохоор тэд тулгар төрийн үндсийг тавьсан өвөг дээдсийнхээ онгоныг аюулгүй газар тавилгүй юунд ширүүн байлдаан болж буй газарт авчрах билээ.

Дээр өгүүлсэн гурван зүйлийн нотолгоо болон таван зүйлийн няцаалт нь Чингис хааны онгон оршлын газар орон лавтайяа эртний монголын хаант улсын нийслэл Хар хорумын хуучин бууриас хойш гучин газрын үзүүрт байгаа Сэлэнгэ мөрний эх үүсвэр дэх Бор өндөр, Гурван хийдийн газар гэдгийг гэрчилж байна.

Дэлхий ертөнцийн хүмүүс түүхэн бичгийн тэмдэглэл дэх уулын өнгө зүс шинж

байдлаар эш баримт болгож байгаад нэгэн үеийн тэнгэрлэг хөвгүүн Чингис хааны онгон оршлын газар орныг олж тогтоохын хамт Чингис хааны хойчис Юань улсын бүх хаадын онгон байгаа газрыг мэдэхийг хүсч байна.

Бүх дэлхийн монгол судлалын эрдэмтэд, эртний газар зүйн судлаачид идэвхтэйгээр харилцан туслалцаж, хамтран сурвалжилж, судалгааг гүнзгийрүүлэх хүсэлтэй байна ... гээд эцэст нь “Монгол хүн дээдсийнхээ онгоныг ухаж малтах ёс заншил үгүй юм. Чингис хааны онгон шарилыг олж илрүүлсний дараа хана хэрэм босгож, хашаа хүрээ барьж хүрээлээд дэлхий нийтэд соёлын үнэт зүйлс болгон соёрхуулсугай хэмээн бодсон билээ” гэжээ.